

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



АУДИТЫН ТАЙЛАН

Аудитын сэдэв: ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН
ЗАХИРАГЧИЙН 2025 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

АУДИТЫН КОД: ӨМА-2026/02-15/СТА-НА-НТГ



Даланзадгад хот 2026

Дарга, Тэргүүлэх аудитор Ц.Өсөхбаяр
Утас: 70533539 Цахим хаяг: Usukhbavarts@audit.gov.mn
Аудитын менежер Т.Хонгорзул
Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn
Ахлах аудитор Г.Шижирболд
Утас: 70533552 Цахим хаяг: Shijirboldg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу: Цахим хаяг: www.audit.mn

Аудитыг гүйцэтгэсэн:	Агуулга	Хуудас
Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр	Товчилсон үгийн тайлбар	3
	Хүснэгт, график, зургийн жагсаалт	3
	Аудитын зорилт, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл	4
Аудитын менежер: Т.Хонгорзул	Бүлэг 1. Төсвийн орлогын төлөвлөгөө 391,449.5 сая төгрөгөөр тасарсан байна.	6
Ахлах аудитор: Г.Шижирболд	Бүлэг 2. Улсын төсөвт 1,111,000.0 сая төгрөг төвлөрүүлсэн нь нийт зарлагын 68.7 хувийг эзэлж байна.	12
Аудитор: Т.Будсүрэн Ө.Болортуяа О.Чойдорж	Бүлэг 3. Нэмэлт төсвийг холбогдох журмын дагуу зарцуулсан байна.	20
	Дүгнэлт	22
	Зөвлөмж	23
	Тэргүүлэх аудиторын тушаал	24

2026 оны 04 дүгээр сар

Аудитын тайлан,
дүгнэлттэй холбоотой
асуудлаар нэмж
тодруулах, асууж
лавлах зүйл байвал
70533539, 70533552
дугаарын утсаар харилцана
уу.

Тайланг ӨМТАГ-ын
www.umnugovi@audit.gov.mn
цахим хуудаснаас үзнэ үү.

Хаяг: Нутгийн удирдлагын
ордон, 3 давхар, 303 тоот

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

УИХ	Улсын Их хурал
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ТТАМНАТ	Түгээмэл тархацтай ашигт малтмал нөөц ашигласны төлбөр
ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
АМНАТ	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
ОНХН	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн
ОАТ	Орлогын албан татвар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНТХО	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт
БХ-ХО	Байгаль хамгаалах хөрөнгө оруулалт

Хүснэгт, графикийн жагсаалт

Дугаар	Тайлбар	Хуудас
Хүснэгт 1	Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөлт	6
Хүснэгт 2	Орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэл	7
Хүснэгт 3	Төсвийн орлогын гүйцэтгэл нэр төрлөөр	8
Хүснэгт 4	Төсвийн орлогын гүйцэтгэл аймаг, сумдаар	9
Хүснэгт 5	ААНОАТ-ийн дахин хуваарилалт	10
Хүснэгт 6	Орон нутгийн төсвийн зарлагын төлөвлөлт	12
Хүснэгт 7	Орон нутгийн төсвийн зарлагын гүйцэтгэл	13
Хүснэгт 8	<i>Улсын төсөвт төвлөрүүлсэн дүн</i>	14
Хүснэгт 9	Хөтөлбөрөөр	15
Хүснэгт 10	Дэд хөтөлбөрүүдийн төсөв, гүйцэтгэл	16
Хүснэгт 11	Худалдан авах ажиллагааны товчоо	17
Хүснэгт 12	Баталсан төсөл арга хэмжээний жагсаалт	18
Хүснэгт 13	Хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний жагсаалт	19
Хүснэгт 14	Нэмэлт төсвийн гүйцэтгэл	20
Хүснэгт 15	Нэмэлт төсвийн гүйцэтгэл сумдаар	20

Аудитын зорилт, арга зүйн талаарх мэдэгдэл

Аудит хийх үндэслэл:

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасны дагуу МУЕА-ын 2025 оны А/179 дугаар тушаалыг үндэслэн аудит хийв.

Аудитын зорилт:

Өмнөговь аймгийн Төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2025 оны төсвийн гүйцэтгэлийн тайланг холбогдох хууль тогтоомж, стандарт, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн актын шаардлагад нийцүүлэн үнэн зөв тайлагнасан эсэхийг баталгаажуулж, дүгнэлт гарган Үндэсний аудитын газар, Өмнөговь аймгийн Засаг даргад танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2025 оны нэгдсэн төсвийн орлогыг хууль тогтоомжийн дагуу бүрэн бүрдүүлж, үнэн зөв тайлагнасан эсэх;
- Нэгдсэн төсвийн зарлага ба цэвэр зээлийг хууль тогтоомжийн дагуу зарцуулж, үнэн зөв тайлагнасан эсэх;
- Нэмэлт төсвийг хуулийн дагуу бүрдүүлэн зарцуулж, үнэн зөв тайлагнасан эсэх;

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100, 300, 3000-д нийцүүлэн баталсан болон Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит, тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Гүйцэтгэлийн аудитын зарчим”, MNS 6817-7:2020 “Гүйцэтгэлийн аудитын стандарт”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, 2021 оны А/69 дүгээр тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”, 2021 оны А/71 дүгээр тушаалаар баталсан “Нийцлийн аудитын заавар, аргачлал”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт, түүвэрлэлт хийх, судалгаа явуулах, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, арга зүйг ашиглав.

Хамрах хүрээ:

Аудитад Өмнөговь аймгийн 2025 оны төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл, татварын зарлагыг хуулийн этгээд, салбар бүрээр, холбогдох эрх зүйн үндэслэл, худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэл, хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга, нэмэлт төсвийн гүйцэтгэл, түүний танилцуулга болон бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан гүйцэтгэв.

Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн, хугацаа:

Аудитыг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Ц.Өсөхбаяр удирдаж, аудитын менежер Т.Хонгорзул арга зүйгээр хангаж, ахлах аудитор Г.Шижирболд, аудитор Т.Будсүрэн, Ө.Болортуяа, О.Чойдорж нар 2026 оны 04 дүгээр сарын 08-ны өдрөөс 2026 оны 04 дүгээр сарын 24-ны өдөр хүртэл хугацаанд гүйцэтгэлээ.

Үндсэн мэдээлэл:

Төсвийн тухай хуулийн 54.1 дүгээр зүйлд “Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд улс, орон нутгийн төсвийн санхүүгийн тайлан, төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн тайлан хамаарна”, 54.2 дугаар зүйлд “Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллагын санхүүгийн тайлан, Засгийн газрын шугамаар авч, ашиглаж байгаа хөнгөлөлттэй зээл болон буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүгийн тайлан, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн тайланг санхүүгийн нэгтгэсэн тайланд хамааруулна” гэж заасны дагуу 2025 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэсэн байна.

Сангийн сайдын 2015 оны 341 дугаар тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан гаргах аргачлал”-ын дагуу нэвтрэлтийн нэгдсэн системийн “finperform” онлайн программаар нэгтгэн гаргасан байна.

Орон нутгийн төсвийн нийт зарлагад 2,225,808.0 сая төгрөгийг баталж, 1,609,297.3 сая төгрөгийг зарцуулж, 72.3 хувийн гүйцэтгэлтэй гарч, батлагдсан төсөв хэтрээгүй байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд хамрагдсан байгууллагуудын хоорондын ажил гүйлгээний давхардсан дүнг төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын хоорондын тооцоогоор баталгаажсан 2,298,617.4 сая төгрөгөөр санхүүгийн байдлын тайланд, 2,755,761.1 сая төгрөгөөр санхүүгийн үр дүнгийн тайланд, 2,731,868.5 сая төгрөгөөр мөнгөн гүйлгээний тайланд устгал хийсэн байна.

БҮЛЭГ 1 Төсвийн орлогын төлөвлөгөө 391,449.5 сая төгрөгөөр тасарсан байна

1.1 Төсвийн орлогыг өмнөх оны гүйцэтгэлээс 165,447.5 сая төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөсөн байна.

1.1.1 Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Өмнөговь аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны "Өсөлттэй Өмнөговь" мөрийн хөтөлбөр зэрэг урт, дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

1.1.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны төсвийг Төсвийн тухай хуулийн 57 дугаар зүйл, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан "Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах" журам, аймгийн 2025 оны төсвийн төсөл, өмнөх оны гүйцэтгэл, холбогдох бусад хууль эрх зүйн актуудыг үндэслэн төлөвлөсөн байна.

1.1.3 Өмнөговь аймгийн төсвийн Ерөнхийлөн захирагч Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4¹ заасны дагуу 2026 оны 04 дүгээр сарын 01-ны өдрийн 01/1544 дугаар албан бичгийн хамт аймгийн Засаг даргын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланг ирүүлсэн.

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

1.1.4 Орон нутгийн төсвийн суурь орлогыг Сангийн яамнаас 1,705,216.6 сая төгрөгөөр хянасныг Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35.1.9²-д заасан бүрэн эрхийн хүрээнд аймгийн ИТХ-ын 2024 оны 03/14 дугаар "Аймгийн 2025 төсөв батлах тухай" тогтоол, сумдын ИТХ-ын тогтоолоор 2,332,961.7 сая төгрөг болгон нэмэгдүүлэн баталсан байна.

1.1.5 Тайлант хугацаанд Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.2³-д заасны дагуу аймгийн ИТХ-ын 2025 оны 6/19 дугаар "2025 оны төсвийн тодотгол батлах тухай" тогтоолоор аймаг, сумдын нийт төсвийн орлогыг 2,044,513.7 сая төгрөг буюу 288,448 сая төгрөгөөр бууруулан баталсан байна.

Хүснэгт №1 Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөлт /сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	2025 он		
		Сангийн яам хянасан дүн	Анх батлагдсан	Тодотгосон төсөв
Б	1	2	3	4
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	1,879,066.3	1,705,216.6	2,332,961.7	2,044,513.7
ТАТВАРЫН ОРЛОГО	1,647,872.9	1,561,918.0	2,088,615.8	1,785,638.5
Орлогын албан татвар	1,394,466.4	1,225,940.0	1,771,647.3	1,483,758.2
Хувь хүний орлогын албан татвар	235,244.4	278,440.0	320,192.5	302,937.9
Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрх	215,185.3	262,520.0	303,277.3	285,372.1
Үйл ажиллагааны орлого	1,932.4	1,050.0	1,107.1	1,094.5
Хөрөнгийн орлого	2,528.6	3,540.0	3,489.8	3,475.7
Хөрөнгө борлуулсны орлого	1,124.3	830.0	268.3	924.5
Шууд бус орлого	14,473.9	10,500.0	12,050.0	12,071.0
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(2,139.0)	(2,500.0)	(2,500.0)	(2,317.4)
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(2,139.0)	(2,500.0)	(2,500.0)	(2,317.4)

¹ "аймаг, нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагч жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж....."

² Засаг даргын өргөн мэдүүлснээр тухайн аймаг, сум, нийслэл, дүүргийн төсвийг хэлэлцэж батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гүйцэтгэлийг батлах

³ тухайн жилийн төсөв, түүний тодотголын төслийг хэлэлцэн батлах, хэрэгжилтэд хяналт тавих, нийтэд мэдээлэх

Өмнөговь аймгийн ТЕЗ-ын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ААН-ын орлогын албан татвар	1,161,360.9	950,000.0	1,453,954.8	1,183,137.8
ААН-ын орлогын албан татвар	1,161,360.9	950,000.0	1,453,954.8	1,183,137.8
Хөрөнгийн албан татвар	204,409.0	281,629.0	250,721.0	246,632.7
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	191,426.1	268,564.0	236,702.2	232,802.7
Бууны албан татвар	47.5	45.0	46.2	45.0
Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	12,283.0	13,020.0	13,020.0	13,020.0
Малд ногдуулах албан татвар	652.4	-	952.6	765.0
Бусад нийтлэг төлбөр, хураамж	3,563.2	2,730.0	3,301.5	3,339.2
Улсын тэмдэгтийн хураамж	1,332.6	680.0	1,212.2	1,237.5
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	1,613.5	1,500.0	1,532.0	1,539.5
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	617.1	550.0	557.3	558.3
Газрын төлбөр	15,249.8	13,965.0	23,337.2	14,124.3
Газрын төлбөр	14,599.8	13,965.0	14,337.2	14,124.3
Дуудлага худалдаа	650.0	-	9,000.0	-
Байгалийн нөөц ашигласны төлбөр	29,790.4	37,354.0	37,366.3	37,488.0
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	563.3	454.0	444.8	568.6
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	29,227.2	36,900.0	36,921.5	36,919.4
Бусад татвар	394.0	300.0	2,242.4	300.0
Бусад татвар	394.0	300.0	2,242.4	300.0
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	231,193.3	143,298.6	244,346.0	258,875.3
Нийтлэг татварын бус орлого	184,958.9	143,188.6	177,682.4	209,964.3
Хувьцааны ногдол ашиг	150,304.6	130,500.0	160,500.0	186,940.4
Торгуулийн орлого	19,563.0	11,281.2	7,105.7	13,233.6
Төсөв байгууллагын өөрийн орлого	6,258.2	45.0	8,337.3	8,029.1
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	-	352.4	352.4
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,258.2	-	7,984.9	7,676.7
Газрын тосны орлого	99.3	100.4	100.4	99.1
Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	2,500.0	-	5,000.0	5,000.0
Түрээсийн орлого	134.0	112.0	135.0	135.0
Бусад орлого	6,099.7	1,150.0	1,504.1	1,527.1
Хөрөнгийн орлого	208.6	110.0	893.0	121.3
Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого	208.6	110.0	893.0	121.3
Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	46,025.8	-	60,770.5	43,789.7
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	46,025.8	-	60,770.5	43,789.7

Эх сурвалж: Өмнөговь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгдсэн тайлан

1.1.6 Төсвийн нийт орлогыг өмнөх оны гүйцэтгэлээс 8.8 хувиар буюу 165,447.5 сая төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөсөн байна.

1.1.7 Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулиар орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон улсын төсвөөс орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг 43,789.6 сая төгрөг байхаар баталсан байна.

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫН ГҮЙЦЭТГЭЛ

1.2 Төсвийн орлогыг төлөвлөгөө 391,449.5 сая төгрөгөөр дутуу биелсэн байна.

1.2.1 Өмнөговь аймгийн ИТХ-ын 2025 оны 6/19 дүгээр тогтоол болон сумдын ИТХ-ын “2025 оны төсвийн тодотгол батлах тухай” тогтоолоор аймгийн төсөвт 2,044,513.7 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээр баталж, гүйцэтгэлээр 1,653,064.2 сая төгрөгийн орлого төвлөрүүлэн батлагдсан төлөвлөгөөг 80.9 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт №2 Орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь

Өмнөговь аймгийн ТЕЗ-ын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Б	1	2	3	4=3-2	5=3/2
НИЙТ ОРЛОГО	1,879,083.5	2,044,513.7	1,653,064.2	- 391,449.5	80.9
А. Төсвийн орлого	1,832,849.1	2,000,602.7	1,609,733.9	- 390,868.8	80.5
I.Татварын орлого	1,647,808.0	1,785,638.5	1,386,997.5	- 398,641.0	77.7
II. Татварын бус орлого	182,541.1	258,875.3	266,066.7	7,772.2	103.6
Б. Хөрөнгийн орлого	208.6	121.3	274.3	153.0	226.1
В. Тусламж, санхүүжилтийн орлого	48,525.8	43,789.7	43,056.0	-733.7	98.3

Эх сурвалж: Өмнөговь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгдсэн тайлан

1.2.2 Аймгийн нийт орлогын /гүйцэтгэлээр/ татварын орлого 83.9 хувь, татварын бус орлого 16.1 хувийг тус тус эзэлж байна.

1.2.3 Аймаг орон нутгийн зүгээс төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, орон нутгийн төсөв бүрдүүлэх, татварын орлогын бааз суурийг нэмэгдүүлэх чиглэлээр зарим арга хэмжээг зохион байгуулсан боловч орлого тасарсан байна.

1.2.4 Төсвийн орлогын гүйцэтгэлийг үзүүлэлт тус бүрээр авч үзвэл дараах байдалтай байна.

Хүснэгт №3 Төсвийн орлогын гүйцэтгэл нэр төрлөөр

/сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	2025 оны		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
Б	1	2	3	4=3-2
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	1,879,066.3	2,044,513.7	1,653,064.2	- 391,449.5
ТАТВАРЫН ОРЛОГО	1,647,872.9	1,785,638.5	1,386,997.5	- 398,641.0
Орлогын албан татвар	1,394,466.4	1,483,758.2	1,074,556.0	- 409,202.2
Хувь хүний орлогын албан татвар	235,244.4	302,937.9	305,957.4	3,019.6
Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрх	215,185.3	285,372.1	285,062.6	- 309.6
Үйл ажиллагааны орлого	1,932.4	1,094.5	1,518.6	424.1
Хөрөнгийн орлого	2,528.6	3,475.7	2,924.7	- 551.0
Хөрөнгө борлуулсны орлого	1,124.3	924.5	1,103.9	179.4
Шууд бус орлого	14,473.9	12,071.0	15,347.7	3,276.7
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-2,139.0	-2,317.4	-2,317.4	0.0
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-	-	-	0.0
ААН-ын орлогын албан татвар	1,161,360.9	1,183,137.8	770,916.0	- 412,221.8
ААН-ын орлогын албан татвар	1,161,360.9	1,183,137.8	770,916.0	- 412,221.8
Хөрөнгийн албан татвар	204,409.0	246,632.7	258,937.9	12,305.2
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	191,426.1	232,802.7	245,913.3	13,110.7
Бууны албан татвар	47.5	45.0	48.8	3.8
Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	12,283.0	13,020.0	12,086.2	- 933.8
Малд ногдуулах албан татвар	652.4	765.0	889.5	124.5
Бусад нийтлэг төлбөр, хураамж	-	55,247.6	53,503.6	- 1,743.9
Бусад нийтлэг төлбөр, хураамж	3,563.2	3,339.2	5,056.5	1,717.3
Улсын тэмдэгтийн хураамж	1,332.6	1,237.5	1,717.0	479.5
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	1,613.5	1,539.5	2,694.3	1,154.8
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	617.1	558.3	645.3	87.0
Газрын төлбөр	15,249.8	14,124.3	16,180.7	2,056.4
Газрын төлбөр	14,599.8	14,124.3	14,485.4	361.1
Дуудлага худалдаа	650.0	-	1,695.3	1,695.3
Байгалийн нөөц ашигласны төлбөр	29,790.4	37,488.0	31,837.0	- 5,651.0
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	563.3	568.6	618.8	50.2
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	29,227.2	36,919.4	31,218.1	- 5,701.2
Бусад татвар	394.0	300.0	429.4	129.4
Бусад татвар	394.0	300.0	429.4	129.4
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	231,193.3	258,875.3	266,066.7	7,191.5

Өмнөговь аймгийн ТЕЗ-ын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Нийтлэг татварын бус орлого	184,958.9	209,964.3	219,736.5	9,772.2
Хувьцааны ногдол ашиг	150,304.6	186,940.4	186,940.7	0.3
Торгуулийн орлого	19,563.0	13,233.6	25,923.2	12,689.6
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	352.4	262.1	- 90.3
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,258.2	7,676.7	3,759.3	- 3,917.4
Газрын тосны орлого	99.3	99.1	-	- 99.1
Түрээсийн орлого	134.0	135.0	201.2	66.2
Бусад орлого	6,099.7	1,527.1	2,649.9	1,122.9
Хөрөнгийн орлого	208.6	121.3	274.3	153.0
Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого	208.6	121.3	274.3	153.0
Тусламжийн орлого	2,500.0	5,000.0	3,000.0	- 2,000.0
Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	2,500.0	5,000.0	3,000.0	- 2,000.0
Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	46,025.8	43,789.7	43,056.0	- 733.7
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	46,025.8	43,789.7	43,056.0	- 733.7

Эх сурвалж: Өмнөговь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгдсэн тайлан

1.2.5 Орлогын төлөвлөгөө 391,449.5 сая төгрөгөөр тасарсан нь орон нутгийн төсвийн суурь орлогыг Сангийн яамнаас өндөр төлөвлөсөн, тайлант оны сүүлээр ААНОАТ-ын орлогын төлөлт, дахин хуваарилалт буурснаас тус тус шалтгаалсан байна.

1.2.6 Төсвийн орлогын гүйцэтгэлийг аймаг, сумдаар харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт №4 Төсвийн орлогын гүйцэтгэл аймаг, сумдаар

/сая төгрөг/

Д/д	Сумын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү /+дутуу, -давсан/	Хувь
1	Баяндалай	1,935.0	1,907.1	27.9	98.6
2	Баян-Овоо	5,280.7	5,346.8	-66.1	101.3
3	Булган	1,177.9	1,268.0	-90.1	107.6
4	Гурвантэс	58,687.3	69,266.0	-10,578.6	118.0
5	Даланзадгад	43,719.5	40,931.3	2,788.2	93.6
6	Мандал-Овоо	1,663.0	2,697.0	-1,034.0	162.2
7	Манлай	2,829.8	2,682.5	-147.2	94.8
8	Ноён	5,265.2	3,931.0	1,334.2	74.7
9	Номгон	3,069.1	3,410.5	-341.4	111.1
10	Сэврэй	1,443.0	1,528.6	-85.7	105.9
11	Ханбогд	369,723.5	391,087.1	-21,363.6	105.8
12	Ханхонгор	3,942.9	4,483.1	-540.3	113.7
13	Хүрмэн	1,958.8	1,901.4	-57.4	97.1
14	Цогт-Овоо	1,566.0	1,635.8	-69.8	104.5
15	Цогтцэций	98,153.4	97,920.1	233.3	99.8
16	Аймаг	1,444,098.7	1,023,067.8	421,030.8	70.8
	Нийт дүн	2,044,513.7	1,653,064.2	391,449.5	80.9

Эх сурвалж: Аудитын судалгаа

1.2.7 Төсвийн орлогын төлөвлөгөөг Баяндалай, Даланзадгад, Ноён, Цогтцэций, аймаг тус тус тасалсан байна. Нүүрсний олборлолт, гадаад худалдаа багассантай холбоотойгоор аж ахуй нэгжүүдийн үйл ажиллагаа доголдсон нь тасрах гол шалтгаан болсон байна.

1.2.8 Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1⁴-д заасантай нийцэхгүй байгаа тул Төсвийн төвлөрүүлэн захирагч нарт төлөвлөгөө биеллээгүйд нөлөөлсөн хүчин зүйлсийг бодитой тодорхойлж, төвлөрүүлж ажиллах зөвлөмж хүргүүлсэн.

1.2.9 Аймгийн ИТХ-ын 2025 оны 6/19 дугаар “2025 оны төсвийн тодотгол батлах тухай” тогтоолоор Гурвантэс сум 44,067.2 сая, Ноён сум 124.3 сая, Ханбогд сум 336,560.4 сая,

⁴ “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх”

Цогтцэций сум 74,610.8 сая, Даланзадгад сум 5,633.8 сая төгрөгийг тус тус аймгийн төсөвт төвлөрүүлэхээр баталсан байна.

1.2.10 Үүнээс Ханбогд сум аймгийн төсөвт 59,060.1 сая төгрөгийг дутуу төвлөрүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д заасантай нийцэхгүй байгаа тул Төсвийн төвлөрүүлэн захирагчид зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

Татварын орлогын талаар

1.2.11 Орон нутгийн төсвийн суурь орлогыг Сангийн яамнаас 1,705,216.6 сая төгрөгөөр хянасан байна. Үүнээс аж ахуй нэгжийн орлогын албан татварын суурь орлогыг 950,000.0 сая төгрөг байхаар хянаж, улсын төсөвт төвлөрүүлэх шилжүүлгийг өмнөх оноос 7.8 хувиар өсгөж 1,530,918.5 сая төгрөгөөр тооцож Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулиар баталсан байна.

1.2.12 Аймгийн ИТХ-аас орон нутгийн чиг үүргийг хэрэгжүүлэх төсвийн эх үүсвэр бүрдүүлэхийн тулд сангийн яам хянасан аж ахуй нэгжийн орлогын албан татварын 40 хувийн орлогын дүнг 233,137.8 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

1.2.13 ААНОАТ-ын 40 хувийн хуваарилалтын 2025 оны гүйцэтгэл 770,916.0 сая төгрөг болж өмнөх оноос 33.6 хувиар буурсан байна

Хүснэгт №5 ААНОАТ-ийн дахин хуваарилалт

Он	2024 он	2025 он	/сая төгрөг/ Өсөлт, бууралтын хувь
Татвар төлөгчийн тоо	4042	5352	32.4
ААНОАТ-аар дахин хуваарилагдсан дүн	1,161,360.9	770,916.0	-33.6

Эх сурвалж: аймгийн татварын газар

1.2.14 Төсвийн орлого бүрдүүлэх чиглэлээр уул уурхайн болон тээврийн компаниуд тэдгээрийн туслан гүйцэтгэх аж ахуйн нэгжийн санхүүгийн болон гүйцэтгэх удирдлагыг хамруулсан арга хэмжээний үр дүнд ААНОАТ төлөгчийн тоо 32.4 хувиар өссөн хэдий ч ААНОАТ-ын дахин хуваарилалтын орлого 33.6 хувиар буурсан нь 2025 оны сүүлээр ААНОАТ-ын төлөлт, дахин хуваарилалт буурснаас шалтгаалсан байна.

1.2.15 Сангийн яамнаас Хөрөнгийн орлого буюу хадгаламжийн хүүгийн орлогын төлөвлөгөөг хэт өндөр төлөвлөсөнтэй холбоотойгоор орлогын төлөвлөгөө 551.0 сая төгрөгөөр тасарсан байна.

1.2.16 Шууд бус орлогын төлөвлөгөө 3,276.7 сая төгрөгөөр давж биелсэн нь 2024 онд хувьцаа эзэмшдэг аж ахуйн нэгжүүдийн ногдол ашиг хуваарилсантай холбоотой байна.

1.2.17 Үл хөдлөхийн хөрөнгийг тооллогын ажлыг татвар төлөгчдийн тооллоготой хамт хэрэгжүүлэн аймгийн хэмжээнд 233 үл хөдлөх хөрөнгийг шинээр бүртгэн үл хөдлөх эд хөрөнгийн албан татварыг төвлөрүүлсэн нь тус орлогын төлөвлөгөө 13,110.7 сая төгрөгөөр давж биелэхэд нөлөөлсөн байна.

1.2.18 Засгийн газрын 2025 оны “Олон улсын худалдааны тарифын нөхцөл байдалтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 132 дугаар тогтоолын дагуу татвар хураамжийг нэмэгдүүлээгүй тул авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар 933.8 сая төгрөгөөр тасарсан байна.

1.2.19 Үйлдвэр, үйлчилгээний усны төлбөрийн орлогын төлөвлөгөө 5,701.2 сая төгрөгөөр тасарсан нь өмнөх онд уул, уурхайн компаниудаас ус ашигласны төлбөрийг урьдчилан төлсөн, Сангийн яамнаас суурь орлогыг хэт өндрөөр төлөвлөсөнтэй холбоотой байна.

1.2.20 Малын тоо толгойн орлогын албан татварыг төвлөрүүлэхээр сумд хариуцсан татварын байцаагч нар татварын өр барагдуулах арга хэмжээг авч ажилласны үр дүнд орлогын төлөвлөгөөг 124.5 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Татварын бус орлогын талаар

1.2.21 Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөө 1,154.8 сая төгрөгөөр давж биелсэн нь Баянхонгор аймгийн Шинэжинст сумаас Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Шивээ хүрэн боомт хүртэлх замын бүтээн байгуулалтын ТТАМНАТ орж ирсэнтэй холбоотой байна.

1.2.22 Төсөвт байгууллагын өөрийн орлогыг 4,007.7 сая төгрөгөөр тасалсан байна. Үүний 65.3 хувийг орон нутгийн хөрөнгө оруулалт дансны авлагын үлдэгдэл эзэлж байна.

1.2.23 Орон нутгийн "Тавантолгой" ХК-ний ТУЗ-ын 2025 оны 11 дугаар тогтоолоор 2024 оны татвар төлсний дараах цэвэр ашгаас ногдол ашиг болгон нэгж хувьцаанд (6,690 төгрөг) тогтоосон бөгөөд орон нутгийн 51 хувьд ногдох хувьцааны ногдол ашиг 186,940.7 сая төгрөг хуваарилагдсан байна.

Тусламж санхүүжилтийн орлогын талаар

1.2.24 ОНХС-д олгох орлогын шилжүүлгээр 43,055.9 сая төгрөг олгож, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд зааснаас 733.7 сая төгрөгийн санхүүжилт дутуу олгосон байна.

1.2.25 Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.9⁵-д заасны дагуу Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрт 5,000.0 сая төгрөг төлөвлөснөөс Эрдэнэс Таван толгой ХК-аас 3,000.0 сая төгрөг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 2,000.0 сая төгрөгөөр тасалсан байна.

1.2.26 Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д заасантай нийцэхгүй байгаа тул аймгийн Засаг даргад гэрээний хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж холбогдох арга хэмжээ авч ажиллах зөвлөмж хүргүүлээ.

⁵ “Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан гэрээний дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нутгийн захиргааны байгууллагад өгсөн хандив, тусламж”

БҮЛЭГ 2 Улсын төсөвт 1,111,000.0 сая төгрөг төвлөрүүлсэн нь нийт зарлагын 68.7 хувийг эзэлж байна

2.1 Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын гүйцэтгэл 72.6 хувьтай байна.

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2.1.1 Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35.1.9⁶-д гэж заасны дагуу хурлын бүрэн эрхийн хэмжээнд Сангийн яамнаас хянасан суурь зарлагыг Өмнөговь аймгийн ИТХ-ын 2024 оны 03/14 дугаар “2025 оны төсөв батлах тухай” тогтоол болон сумдын ИТХ-ын тогтоолоор төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны төсвийн нийт зарлагыг 2,476,119.6 сая төгрөгөөр баталсан байна.

2.1.2 Тайлант хугацаанд Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.2⁷-д заасны дагуу Өмнөговь аймгийн ИТХ-ын 2025 оны 6/19 дугаар “2025 оны төсвийн тодотгол батлах тухай” тогтоол болон сумдын тодотгосон төсвийн тогтоолоор аймгийн нийт зарлагыг 313,820.9 сая төгрөгөөр бууруулан 2,238,837.1 сая төгрөгөөр тодотгон баталсан байна. Улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 238.2 сая төгрөгөөр бууруулсан нь нийт төсвийн 76 хувийг эзэлж байна.

Хүснэгт №6 Орон нутгийн төсвийн зарлагын төлөвлөлт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Сангийн яам хянасан дүн	2025 он		
			Анх батлагдсан	Тодотгосон төсөв	Зөрүү
Б	1	2	3	4	5=4-3
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,904,419.0	76,538.3	2,552,658.0	2,238,837.1	(313,820.9)
УРСГАЛ ЗАРДАЛ	1,459,311.9	65,128.6	2,089,334.1	1,847,899.8	(241,434.4)
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	158,247.1	63,696.0	211,232.6	218,662.8	7,430.1
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	27,201.4	26,760.7	36,837.6	37,457.7	620.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,392.5	3,381.5	4,686.3	4,752.5	66.3
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,038.3	16,101.8	23,436.4	25,476.0	2,039.6
Хангамж, бараа материалын зардал	3,383.1	1,912.5	8,110.5	8,608.0	497.4
Норматив зардал	314.6	92.6	458.7	454.6	(4.1)
Эд хогшил, урсгал засварын зардал	3,607.3	2,058.4	3,993.8	4,223.8	230.1
Томилолт, зочны зардал	461.6	230.1	528.8	656.1	127.3
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	25,348.3	12,358.8	28,255.2	40,359.3	12,104.1
Бараа үйлчилгээний бусад зардал	91,627.3	799.8	104,925.4	96,674.8	(8,250.6)
ХҮҮ	-	381.2	-	-	-
Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр	-	381.2	-	-	-
ТАТААС	119.0	-	192.0	208.2	16.2
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	-	-	-	-	-
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	119.0	-	192.0	208.2	16.2
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	491,972.9	1,051.4	1,877,909.5	1,629,028.8	(248,880.7)
Засгийн газрын урсгал шилжүүлэг	1,286,303.6	-	1,875,610.5	1,626,390.1	(249,220.4)

⁶ “Засаг даргын өргөн мэдүүлснээр тухайн аймаг, сум, нийслэл, дүүргийн төсвийг хэлэлцэж батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гүйцэтгэлийг батлах”;

⁷ “тухайн жилийн төсөв, түүний тодотголын төслийг хэлэлцэн батлах, хэрэгжилтэд хяналт тавих, нийтэд мэдээлэх”

Өмнөговь аймгийн ТЕЗ-ын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Бусад урсгал шилжүүлэг	2,514.8	1,051.4	2,299.0	2,638.7	339.7
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	445,107.1	11,409.7	463,323.8	390,937.3	(72,386.5)
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	-	-	-	-	-
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	899,562.3	76,538.3	2,552,658.0	2,238,837.1	(313,820.9)
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	46,025.8	-	-	43,789.7	43,789.7
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	46,025.8	-	45,585.0	43,789.7	(1,795.3)
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,871,261.2	76,493.3	2,515,078.2	1,987,694.9	(527,383.3)
Орон нутгийн төсвөөс	1,871,261.2	76,493.3	2,454,307.7	1,987,694.9	(466,612.8)
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	6,258.4	45.0	32,579.7	8,029.1	(24,550.6)
ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	2,500.0	-	5,000.0	5,000.0	-
БУСАД ЭХ ҮҮСВЭР	-	-	-	194,323.4	194,323.4

Эх сурвалж: Өмнөговь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгдсэн тайлан

2.1.3 Зарлагын санхүүжилтийн эх үүсвэрийн 2 хувийг улсын төсвөөс, 98 хувийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр тус тус төлөвлөсөн байна.

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛ

2.1.4 Аймгийн ИТХ-ын 2025 оны 6/19 дугаар “2025 оны төсвийн тодотгол батлах тухай” тогтоол болон сумдын тодотгосон төсвийн тогтоолоор аймгийн нийт зарлагыг 2,238,837.1 сая төгрөгөөр баталж гүйцэтгэлээр 1,617,831.7 сая төгрөгийг зарцуулж, төсвийн гүйцэтгэл 72.3 хувьтай байна.

Хүснэгт №7 Орон нутгийн төсвийн зарлагын гүйцэтгэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны төлөвлөгөө	Тайлант оны гүйцэтгэл	Зөрүү +/-
Б	1	2	3	4=3-2
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,904,419.0	2,238,837.1	1,617,831.7	621,005.3
УРСГАЛ ЗАРДАЛ	1,459,311.9	1,847,899.8	1,346,346.4	501,553.4
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	170,374.4	218,662.8	169,549.9	49,112.9
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	27,201.4	37,457.7	33,976.6	3,481.1
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,392.5	4,752.5	4,291.5	461.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,038.3	25,476.0	18,273.7	7,202.3
Хангамж, бараа материалын зардал	3,383.1	8,608.0	7,019.8	1,588.1
Норматив зардал	314.6	454.6	319.7	134.8
Эд хогшил, урсгал засварын зардал	3,607.3	4,223.8	3,512.5	711.3
Томилолт, зочны зардал	461.6	656.1	399.4	256.7
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	25,348.3	40,359.3	31,182.9	9,176.5
Бараа үйлчилгээний бусад зардал	91,627.3	96,674.8	70,573.7	26,101.1
ХҮҮ	-	-	-	-
Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр	-	-	-	-
Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	-	-	-	-
ТАТААС	119.0	208.2	202.0	6.2
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	-	-	-	-
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	119.0	208.2	202.0	6.2
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,288,818.4	1,629,028.8	1,176,594.5	452,434.3
Засгийн газрын урсгал шилжүүлэг	1,286,303.6	1,626,390.1	1,175,015.5	451,374.6
Бусад урсгал шилжүүлэг	2,514.8	2,638.7	1,579.0	1,059.7

Өмнөговь аймгийн ТЕЗ-ын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	445,107.1	390,937.3	271,485.4	119,452.0
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	-	-	-	-
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,926,045.4	2,238,837.1	1,528,746.2	710,090.9
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	46,025.8	43,789.7	43,056.0	733.7
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	-	-	-	-
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	-	-	-
Орон нутгийн төсвөөс	-	-	-	-
Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	46,025.8	43,789.7	43,056.0	733.7
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,871,261.2	1,987,694.9	1,478,642.2	509,052.7
ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	1,871,261.2	1,987,694.9	1,478,642.2	509,052.7
БУСАД ЭХ ҮҮСВЭР / шилжих үлдэгдэл/	-	-	-	-

Эх сурвалж: Өмнөговь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

2.1.5 Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн дагуу улсын төсөвт 1,111,000.0 сая төгрөгийг орлого төвлөрүүлж, гүйцэтгэл 72.6 хувьтай байна.

Хүснэгт №8 Улсын төсөвт төвлөрүүлсэн дүн

/сая төгрөг/

Аймаг, хотын нэр	2023 оны гүйцэтгэл	2024 оны гүйцэтгэл	2025 он		
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
Өмнөговь	456,418.8	1,249,676.3	1,530,918.5	1,111,000.0	419,918.5

Эх сурвалж: Аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэс

2.1.6 Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д заасантай нийцэхгүй байгаа тул аймгийн Засаг даргад орлогыг бүрэн төвлөрүүлэх талаар арга хэмжээ авч ажиллах зөвлөмж хүргүүлээ.

2.1.7 Засгийн газрын 2024 оны 238 дугаар “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” тогтоолоор төрийн албан хаагчид болон бусад салбарын цалин хөлсийг дунджаар 6 хувиар нэмэгдүүлсэн.

2.1.8 Төрийн албаны тухай хуулийн 57 дугаарын зүйлийн 57.17⁸-д заасны дагуу аймгийн 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдсанаар улсын төсвийн байгууллагын албан хаагчдад үндсэн цалингийн 25 хувиар, орон нутгийн төрийн захиргааны албан хаагчид сарын үндсэн цалингаас Даланзадгад суманд 80 хувь, бусад суманд 100 хувь, төрийн үйлчилгээний албан хаагчид сарын үндсэн цалингаас Даланзадгад суманд 60 хувь, бусад суманд 80 хувиар, улс төрийн албан хаагчид үндсэн цалингийн 100 хувиар тус тус тооцож, нийт 16,054.0 сая төгрөгийн “Орон нутгийн нэмэгдэл”-ийг олгосон байна.

2.1.9 Аймгийн ИТХ-ын 2020 оны 2/4, Тэргүүлэгчдийн 2021 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Нутгийн дэм” хөтөлбөрт орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа төсвийн байгууллага болон төрийн чиг үүргийг хэрэгжүүлэх дүрмийн зорилготой байгуулагдсан 100 орон нутгийн өмчит хуулийн этгээд, Улаан загалмайн нийгэмлэг болон улсын төсөвт үйлдвэрийн газрын албан хаагчдыг хамруулан, нийт 32,222.8 сая төгрөг олгосон байна.

2.1.10 Эдгээр цалин хөлс, нэмэгдэл, урамшуулалтай холбоотойгоор цалин хөлс, шимтгэлийн зардал өмнөх оноос 7,674.2 сая төгрөгөөр өссөн байна.

2.1.11 Эрчим хүчний зохицуулах хорооны 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн “Тариф батлах тухай” 25 дугаар тогтоолын дагуу 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дулаан, эрчим хүчний үнийг нэмэгдүүлсэнтэй холбоотойгоор байр ашиглалтын зардал өмнөх оны гүйцэтгэлээс нэмэгдэхэд нөлөөлсөн байна.

⁸ “Захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгож болно”

2.1.12 Аймгийн 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу аймгийн Засаг даргын 2025 оны А/29 дүгээр захирамжаар “Цэцэрлэгийн хүүхдийн хоолны нэмэгдэл зардал олгох”, А/40 дүгээр захирамжаар “Ерөнхий боловсролын сургуулийн 6,7 дугаар ангид Үдийн хоол өгөх”, А/41 дүгээр захирамжаар “Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны хүүхдийн хоолны нэмэгдэл зардал олгох” шийдвэрийн дагуу нийт 2,611.4 сая төгрөгийг зарцуулснаар хангамжийн зардал өмнөх оноос өсөхөд нөлөөлсөн байна.

2.1.13 Даланзадгад сумын Засаг даргын тамгын газар 1, Гурвантэс сумын Засаг даргын тамгын газар 2 албан хаагчаар батлагдсан орон тоог хэтрүүлэн ажиллуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.12⁹-д Ерөнхий сайдын 2025 оны 3 дугаар албан даалгаврын 1.2¹⁰-т гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

2.1.14 Иймд дээрх зөрчлийн арилгуулах тухай албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлээ.

2.1.15 Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн гүйцэтгэлийг хөтөлбөрөөр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт №9 Хөтөлбөрөөр

/сая төгрөг/

№	Хөтөлбөрийн нэр	Төсвийн гүйцэтгэл			
		Төсөв	Гүйцэтгэл	Хэтрэлт, хэмнэлт	Хувь
1	70105 ОН-ын өөрөө удирдах ёсны байгууллага	9,482.1	8,122.7	1,359.4	86%
2	70106 ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага	532,907.5	386,966.9	145,940.6	73%
3	70418 Худалдан авах ажиллагаа	641.6	598.6	42.9	93%
4	70426 Төрийн өмчийн эрхийг хэрэгжүүлэх	1,181.3	883.4	297.8	75%
5	70429 Санхүүгийн хяналт, дотоод аудит, эрсдэлийн удирдлага	490.4	454.5	35.8	93%
6	70501 ОН-ын төсөвт олгох Шилжүүлэг	77,054.8	46,847.1	30,207.7	61%
7	70504 Доод шатны төсвөөс дээд шатны төсөвт төвлөрүүлэх орлого	1,530,918.5	1,111,000.0	419,918.5	73%
8	70602 Хил хамгаалах	1,818.6	1,818.6	-	100%
9	70709 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх	1,038.4	950.8	87.6	92%
10	70801 Мал аж ахуйг хөгжүүлэх	1,559.2	-	1,559.2	0%
11	71101 Авто зам	15,921.6	6,140.8	9,780.8	39%
12	71403 Ойжуулалт	4,985.9	3,921.8	1,064.1	79%
13	71411 Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага	12,630.1	9,151.8	3,478.4	72%
14	71502 Хот байгуулалт, тохижилт	9,377.9	8,637.7	740.2	92%
15	71506 Суурин газрын усан хангамж	208.2	202.0	6.2	97%
16	71602 Эмнэлгийн тусламж үйлчилгээ	8,569.1	7,385.2	1,183.9	86%
17	71701 Биеийн тамир спорт	669.6	565.7	103.9	84%
18	71702 Соёл урлаг	3,164.9	1,934.1	1,230.8	61%
19	71801 Сургуулийн өмнөх боловсрол	6,617.5	5,490.8	1,126.6	83%
20	71802 Ерөнхий боловсрол	13,128.8	10,950.1	2,178.7	83%
21	71804 Мэргэжлийн боловсрол	2,169.4	1,913.8	255.7	88%
22	71806 Насан туршийн болон албан бус боловсрол	37.1	26.0	11.1	70%
23	71902 Нийгмийн халамж	186.2	129.4	56.8	69%
24	72101 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих	568.0	568.0	0.0	100%
25	72207 Хүүхдийн хөгжил, хамгаалал	2,056.1	1,717.4	338.7	84%
26	72208 Ахмад настны хөгжил хамгаалал	1,454.6	1,454.6	0.0	100%
Нийт дүн		2,238,837.1	1,617,831.7	621,005.4	72%

Эх сурвалж: Аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэс

2.1.16 ТЕЗ-ийн харьяа байгууллагуудад батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй, үр ашиггүй зарцуулсан 1,848.6 сая төгрөгийн 110 зөрчил илэрснээс 51.0 сая

⁹ “эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсөвт байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор чиг үүрэг, зохион байгуулалтын бүтцийг батлагдсан орон тооны хязгаар, төсөвт багтаан шинэчлэн тогтоох”

¹⁰ “харьяа байгууллага, хуулийн этгээдийн хэмжээнд сахилга, харуцлагыг чангатгаж, төсвийн үр ашиггүй зардлыг танан, хэмнэлтийн горимыг чанд мөрдөх, бүтэц, чиг үүргийн давхардлыг арилган, орон тоог үе шаттай цөөлөх”

төгрөгийн зөрчилд 28 төлбөрийн акт, 737.2 сая төгрөгийн зөрчилд 61 албан шаардлага, 1,060.4 сая төгрөгийн зөрчилд 21 зөвлөмж тус тус хүргүүлээ.

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН ХӨТӨЛБӨР, АРГА ХЭМЖЭЭ,

2.1.17 Аймгийн ИТХ-ын 2024 оны 03/14 дугаар тогтоолоор орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжих хөтөлбөр, төсөл, арга хэмжээнд 94,793.6 сая төгрөгөөр 128 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

2.1.18 Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.2-д заасны дагуу аймгийн ИТХ-ын 2025 оны 06/19 дугаар тогтоолоор 2024 онд хэрэгжих хөтөлбөр, төсөл арга хэмжээний тоог 110 болгон 3,824.1 сая төгрөгөөр бууруулан 90,969.5 сая төгрөгөөр баталсан нь Ерөнхий сайдын 2025 оны 03 дугаар “Төрийн албаны сахилга, дэг журам, хариуцлагыг чангатгах тухай” албан даалгаврыг хэрэгжүүлсэн байна.

2.1.19 Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл арга хэмжээнд гүйцэтгэлээр 76,494.1 сая төгрөг зарцуулж 89 арга хэмжээг хэрэгжүүлж ажилласан байна. Энэ нь Төсвийн ерөнхийлөн захирагчийн нийт төсвийн зарлагын 4.7 хувийг эзэлж байна.

2.1.20 “Өсөлттэй Өмнөговь” хөтөлбөрийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд 25 хөтөлбөрөөс “Нутгийн номын сан”, “Говь+Ус”, “Хашаандаа сайхан амьдарцгаая” зэрэг 3 хөтөлбөрийг хэрэгжүүлэх төсвийг 2025 оны аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй 2026 оноос хэрэгжүүлж ажиллахаар төлөвлөсөн, “Нутгийн үйлдвэрлэгч” хөтөлбөр 2025 оны 11 дүгээр сард батлагдсан тул дээрх 4 хөтөлбөрийг хасаж 21 хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байна.

2.1.21 Тайлант онд дэд хөтөлбөрүүдэд 74,131.5 сая төгрөг зарцуулахаар баталж гүйцэтгэлээр 40,730.4 сая төгрөг зарцуулсан байна.

Хүснэгт №10 Дэд хөтөлбөрүүдийн төсөв, гүйцэтгэл

/сая төгрөг/

№	Хөтөлбөрийн нэр	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	Гүйцэтгэлийн хувь
1.Нийгмийн салбарын чиглэл					
1	"Эх хүүхдийн эрүүл мэнд" хөтөлбөр	100.0	64.5	35.5	64%
2	"Сүү тараг" хөтөлбөр	250.0	219.1	30.9	88%
3	"Эрүүл элэг" хөтөлбөр	50.0	13.9	36.1	28%
4	"Эрүүл шүд" хөтөлбөр	700.0	487.8	212.2	70%
5	"Эзэмшсэн мэргэжлээрээ эх нутагтаа ажиллая" хөтөлбөр	700.0	669.3	30.8	96%
6	"Сурагч солилцоо" хөтөлбөр	25.0	24.1	0.9	96%
7	"Чадварлаг багш" хөтөлбөр	572.1	529.0	43.1	92%
8	"Говийн ирээдүй хүүхэд" хөтөлбөр	150.0	145.0	5.0	97%
9	"Математик боловсролын хөгжил" хөтөлбөр	150.0	101.8	48.2	68%
10	"Өсөлтийг өрх бүрд" хөтөлбөр	500.0	489.5	10.5	98%
11	"Гэр бүл, хүүхэд, эмэгтэйчүүдийн хөгжил хамгааллыг сайжруулах" хөтөлбөр	60.0	42.9	17.1	71%
12	"Залуус" хөтөлбөр	385.0	186.9	198.1	49%
13	"Өмнөговь аймгийн Соёлын өв" хөтөлбөр	300.0	294.6	5.4	98%
2. Хөдөө аж ахуй, хөрөнгө оруулалт, байгаль орчны чиглэл					
14	"Цахим Өмнөговь" хөтөлбөр	368.0	92.4	275.6	25%
15	"Шинэ мянган айл" хөтөлбөр	22,385.8	27,386.7	(5,001.0)	122%
16	"Шинэ хороолол" хөтөлбөр	6,857.2	6,857.2	-	100%
17	"Чинээлэг малчин өрх" хөтөлбөр	807.7	505.3	302.4	63%
3. Хүний нөөцийн хөгжлийн чиглэл					

Өмнөговь аймгийн ТЕЗ-ын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

18	"Хөгжлийн гүүр" хөтөлбөр	1,100.0	1,098.7	1.3	100%
19	"Төрийн албан хаагчийн сургалт, нөхцөл, нийгмийн баталгааг хангах" хөтөлбөр	700.0	691.8	8.2	99%
4. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэл					
20	"Архидан согтуурах, мансууруулах бодистой тэмцэх, архинаас татгалзсан иргэдийг нийгэмшүүлж, ажлын байраар хангах" хөтөлбөр	850.8	709.6	141.2	83%
21	"Ээлтэй Өмнөговь" хөтөлбөр	120.0	120.0	0.0	100%
ДҮН		37,131.5	40,730.0	-3,598.4	

Эх сурвалж: Аймгийн Хяналт- шинжилгээ үнэлгээний хэлтэс

2.1.22 Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Хяналт-шинжилгээ хийх журам”-ын дагуу Өмнөговь аймгийн 2024-2028 онд хэрэгжүүлэх аймгийн Засаг даргын үйл ажиллагааны “Өсөлттэй Өмнөговь” хөтөлбөрийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж 35.6-89.7 хувиар дүгнэсэн байна.

2.1.23 Хөтөлбөр, арга хэмжээтэй холбоотой гарсан зөрчлүүдэд ТЕЗ-ын тайланд хийсэн санхүүгийн аудитаар аймгийн Засаг даргад албан шаардлага, зөвлөмж хүргүүлсэн.

2.1.24 Тайлант онд төсөвт тусгагдаагүй шинэ хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлээгүй байна. Зарим хөтөлбөрийн хүрэх түвшин хэт ерөнхий, хэрэгжилтийг хангалтгүй тайлагнасан, төсөвтэй уялдуулан тайлагнаагүй, үр дүнгийн танилцуулгыг бэлтгээгүй байна.

2.2 Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний биелэлт 59 хувь байна.

ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР:

2.2.1 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийх ТЕЗ-ийн 2025 оны Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 263,721,591 сая төгрөгийн 325 төсөл, арга хэмжээ батлагдсан. Аймгийн 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх хүрээнд аймгийн ИТХ-ын тодотголоор 77 ажил, үйлчилгээ батлагдаж нийт 270,921.6 сая төгрөгийн 402 бараа, ажил үйлчилгээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар төлөвлөж харьяа байгууллага, 15 сумдын ЗДТГ-т 78 ажил, бараа, үйлчилгээний эрхийг шилжүүлсэн байна.

Хүснэгт №11 Худалдан авах ажиллагааны товчоо

№	Захиалагч байгууллагын нэр	2025 он				
		Төсөл арга хэмжээ	Төсөв (сая. төгрөг)	Гэрээ байгуулах эрх олгогдсон ТАХ	Амжилтгүй /зохион байгуулагд аагүй ТАХ	Биелэлт ийн хувь
1	Аймгийн худалдан авах ажиллагааны газар	302	229,381	140	162	46
2	Баяндалай сумын Засаг даргын Тамгын газар	40	2,895	17	23	43
3	Баян-Овоо сумын Засаг даргын Тамгын газар	49	7,708	23	26	47
4	Булган сумын Засаг даргын Тамгын газар	28	1,718	18	10	64
5	Гурвантэс сумын Засаг даргын Тамгын газар	65	20,355	45	20	69
6	Даланзадгад сумын Засаг даргын Тамгын газар	88	41,989	69	19	78
7	Мандал-Овоо сумын Засаг даргын Тамгын газар	23	1,447	16	7	70
8	Манлай сумын Засаг даргын Тамгын газар	39	10,041	19	20	49

Өмнөговь аймгийн ТЭЗ-ын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

9	Ноён сумын Засаг даргын Тамгын газар	28	3,367	20	8	71
10	Номгон сумын Засаг даргын Тамгын газар	40	2,961	30	10	75
11	Сэврэй сумын Засаг даргын Тамгын газар	28	5,459	19	9	68
12	Ханбогд сумын Засаг даргын Тамгын газар	67	78,582	54	13	81
13	Ханхонгор сумын Засаг даргын Тамгын газар	36	2,450	28	8	78
14	Хүрмэн сумын Засаг даргын Тамгын газар	33	2,394	5	28	15
15	Цогт-Овоо сумын Засаг даргын Тамгын газар	39	4,258	26	13	67
16	Цогтцэций сумын Засаг даргын Тамгын газар	97	71,439	67	30	69
Нийт:		1002	486,443	596	406	59

Эх сурвалж: Худалдан авах ажиллагааны газар

2.2.2 Амжилтгүй болсон төсөл, арга хэмжээнүүд нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.1.1, 13.1.2, 13.1.3, 13.1.4 дэх заалтад тус тус заасны дагуу хасагдсан, оролцогчгүй, хуулийн хугацаанд худалдан авах ажиллагаа зохион байгуулагдаагүй, захиалагчаас ажлын даалгавар, техникийн тодорхойлолт ирээгүйтэй холбоотой байна.

2.2.3 Аймгийн худалдан авах ажиллагааны газраас худалдан авах ажиллагааг цахим системээр нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 253, харьцуулалтын аргаар 49 зохион байгуулсан байна.

2.2.4 ТЭЗ-ийн худалдан авах ажиллагаа зохион байгуулсан 202 төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалттай холбоотой нийт 32 гомдол гарснаас Сангийн яам - 27, Монополын эсрэг газарт- 5 гомдол гарсныг холбогдох албан бичгийн дагуу шийдвэрлэсэн байна.

2.2.5 Төсөл хөтөлбөр “Говийн Оюу” хөгжлийг дэмжих сангаас санхүүжих 2,644.8 сая төгрөгийн нийт 11 төсөл, арга хэмжээг Сангийн яамны зөвшөөрлөөр Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нэмэлт оруулж хэрэгжүүлсэн байна.

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТАЛААР:

2.2.6 Аймгийн 2025 оны хөрөнгө оруулалтын зардлыг Монгол Улсын Төсвийн тухай хууль, холбогдох журам, ИТХ-ын 2024 оны 03/14, 2025 оны 6/19 дүгээр тогтоолуудаар баталсан төсөв, төсвийн тодотголын дагуу төлөвлөж, хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт№12 Баталсан төсөл арга хэмжээний жагсаалт (сая.төгрөг)

Төсөл, арга хэмжээний нэр	2024 оны ИТХ-ын тогтоол №03/14		2025 оны ИТХ-ын тогтоол №6/19 тодотгол	
	Тоо	санхүүжих дүн	Тоо	санхүүжих дүн
Орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ	28	37,810.8	30	32,762.1
Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ	221	282,620.8	227	211,005.8
Байгаль хамгаалах чиглэлийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалт	53	12,915.0	53	10,170.2
Замын сангийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалт	1	15,000.0	1	15,000.0
Нийт дүн	303	348,346.7	311	268,938.2

Эх сурвалж: Аймгийн ИТХ-ын тогтоол

2.2.7 Хөрөнгө оруулалт нь орон нутгийн хөгжлийг дэмжих, иргэдийн амьдрах орчныг сайжруулах, нийгмийн суурь үйлчилгээг өргөжүүлэх зорилготойгоор дэд бүтэц, нийгмийн салбар, байгаль орчин, хот байгуулалтын чиглэлд төлөвлөсөн байна.

2.2.8 Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд 177,155.3 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Хүснэгт №13 Хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний жагсаалт (сая.төгрөг)

Нэр	Төлөвлөгөө		Гүйцэтгэл	
	Арга хэмжээний тоо	Баталсан төсөв	Арга хэмжээний тоо	Олгосон санхүүжилт
Орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ	30	32,762.1	24	21,693.2
Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ	227	211,005.8	300	163,474.4
Байгаль хамгаалах чиглэлийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалт	53	10,170.2	42	8,461.7
Замын сангийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалт	1	15,000.0	3	5,219.2
Нийт дүн	311	268,938.2	369	198,848.5

Эх сурвалж: Аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэс

2.2.9 Төрийн аудитын тухай тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд “Улс, орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д гүйцэтгэлийн аудитыг гүйцэтгэж байна.

2.2.10 Гүйцэтгэлийн аудит хийж дуусаагүй байгаа тул орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний гүйцэтгэл үр дүнг тайлагнах боломжгүй байна.

БҮЛЭГ 3 Нэмэлт төсвийг холбогдох журмын дагуу зарцуулсан байна.

3.1 Нэмэлт төсвийн эх үүсвэрийг хуулийн дагуу бүрдүүлсэн байна.

3.1.1 Төсвийн шууд захирагчид нэмэлт төсвийг Төсвийн тухай хуулийн 47¹¹ дугаар зүйлд заасны дагуу бүрдүүлж аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгүүлэн ажилласан байна.

3.1.2 ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын нэмэлт санхүүжилтийн дансанд 39,652.1 сая төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж 1,340.2 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

3.1.3 Нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрсөн төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламжаар 15.0 сая төгрөг, ЗГНХ, ЗДНХөрөнгө түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 37,088.6 сая төгрөг, Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 313.7 сая төгрөг, Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 2,234.6 сая төгрөг нийт 39,652.1 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн байна.

3.2 Нэмэлт төсвийн санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

3.2.1 Нэмэлт төсвийг зарцуулалтын 76.7 хувийг хөрөнгийн зардалд зарцуулсан байна.

Хүснэгт №14 Нэмэлт төсвийн гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Мөнгөн дүн	/сая төгрөг/ Эзлэх хувь
1	Цалин хөлс болон болон нэмэгдэл урамшуулал	4,199.4	11.0
2	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	511.6	1.3
3	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17.3	0.0
4	Хангамж, бараа материалын зардал	192.4	0.5
5	Нормативт зардал	181.5	0.5
6	Эд хогшил, урсгал засварын зардал	271.3	0.7
7	Томилолт, зочны зардал	121.8	0.3
8	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал	513.4	1.3
9	Бараа үйлчилгээний бусад зардал	2,765.4	7.2
10	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардал	148.6	0.4
11	Хөрөнгийн зардал	29,389.4	76.7
Нийт дүн		38,311.9	100.0

Эх сурвалж: Санхүү төрийн сангийн хэлтэс

3.2.2 ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын нэмэлт санхүүжилтийн гүйцэтгэл 2024 онд 52,668.2 сая төгрөг, 2025 онд 38,311.9 сая төгрөг буюу өмнөх оноос 14,356.9 сая төгрөг, 27.2 хувиар буурсан байна.

Хүснэгт №15 Нэмэлт төсвийн гүйцэтгэл сумдаар

№	Сумдын нэр	Өмнөх оны гүйцэтгэл	2025 он		
			Санхүүжилт	Зарцуулалт	Төвлөрүүлсэн дүн
1	Баяндалай	195.9	293.4	210.3	83.1
2	Баян-Овоо	256.1	236.3	229.1	7.2
3	Булган	9,031.9	668.2	656.3	11.9
4	Гурвантэс	7,118.3	1,437.60	1,422.50	15
5	Мандал-Овоо	1,682.7	276.9	254.9	22
6	Манлай	460.6	3,793.90	3,747.90	46
7	Номгон	2,387.5	358.1	357.5	0.6

¹¹ "Нэмэлт төсөв"

Өмнөговь аймгийн ТЕЗ-ын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

8	Ноён	4,665.7	787.2	754.6	32.6
9	Сэврэй	4,711.2	4,448.10	4,447.30	0.9
10	Ханбогд	8,021.1	510.2	476	34.2
11	Ханхонгор	657.9	320.6	288.9	31.8
12	Хүрмэн	2,788.4	230	212.6	17.3
13	Цогт-Овоо	208.9	2,966.10	2,409.40	556.6
14	Цогтцэций	2,433.9	4,885.80	4,630.70	255.1
15	Даланзадгад	1,085.2	14,452.80	14,395.60	57.2
16	Аймгийн төвийн төсвийн байгууллагууд	6,963.5	3,986.90	3,818.30	168.7
Дүн		52,668.8	39,652.1	38,311.9	1,340.2

Эх сурвалж: Санхүү төрийн сангийн хэлтэс

3.2.3 Нэмэлт санхүүжилтийн 83.2 хувь буюу 13,572.6 сая төгрөг нь бараа үйлчилгээний зардал, 11.6 хувь буюу 1,885.5 сая төгрөг нь урсгал шилжүүлэг, 5.2 хувь буюу 854.3 сая төгрөг нь хөрөнгийн зардал байна.

3.2.4 ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын нэмэлт санхүүжилтийн дансанд санхүүгийн тайлангийн аудитаар нийт 9 байгууллагад 494.8 сая төгрөгийн 15 алдаа зөрчлийг илрүүлж, 101.9 сая төгрөгийн 1 зөрчилд таслан зогсоох, санхүүгийн үйл ажиллагааг сайжруулах зөвлөмж өгч, 292.7 сая төгрөгийн зөрчилд давтан гаргахгүй байх 10 албан шаардлага хүргүүлж, 100.1 сая төгрөгийн 4 зөрчилд төлбөрийн акт тогтоосон байна.

Аудитын дүгнэлт

Аудитаар илрүүлсэн зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

Үүнд:

- Аймгийн ИТХ-ын 2025 оны 6/19 дугаар “2025 оны төсвийн тодотгол батлах тухай” тогтоолоор аймаг, сумдын нийт төсвийн орлогыг 2,044,513.7 сая төгрөг буюу 288,448 сая төгрөгөөр бууруулан баталсан байна
- Аймгийн нийт орлогын /гүйцэтгэлээр/ татварын орлого 83.9 хувь, татварын бус орлого 16.1 хувийг тус тус эзэлж байна.
- Зарлагын санхүүжилтийн эх үүсвэрийн 2 хувийг улсын төсвөөс, 98 хувийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.
- Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн дагуу улсын төсөвт 1,111,000.0 сая төгрөгийг орлого төвлөрүүлж, гүйцэтгэл 72.6 хувьтай байна.
- Аймгийн ИТХ-ын 2024 оны 03/14 дугаар тогтоолоор орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжих хөтөлбөр, төсөл, арга хэмжээнд 94,793.6 сая төгрөгөөр 128 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.
- Тайлант онд дэд хөтөлбөрүүдэд 74,131.5 сая төгрөг зарцуулахаар баталж гүйцэтгэлээр 40,730.4 сая төгрөг зарцуулсан байна.
- ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын нэмэлт санхүүжилтийн дансанд 39,652.1 сая төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж 1,340.2 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Аудитын зөвлөмж

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.

Өмнөговь аймгийн Засаг дарга Н.Энхбат танаа:

1. Улсад төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө биелээгүйд нөлөөлсөн хүчин зүйлсийг бодитой тодорхойлж, төлөвлөлт, гүйцэтгэл, хяналтын уялдааг сайжруулах,
2. "Эрдэнэс Таван толгой" ХК-тай 2023 онд байгуулсан хамтын ажиллагааны гэрээний дагуу хандив тусламжийн орлого жил бүр тасарч байгаад дүн шинжилгээ хийж, холбогдох арга хэмжээ авч ажиллах

Зөвлөмжүүдийн хэрэгжилтийг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Дарга, Тэргүүлэх аудиторын тушаал



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2026 оны 04 сарын _____ өдөр

Дугаар A/15

Даланзадгад сум

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, 8 дугаар зүйлийн 8.1, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны A/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18.9, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны A/102 дугаар “Эрх шилжүүлэх тухай” тушаалын дөрөвдүгээр хавсралтын 1.4-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Өмнөговь аймгийн Төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг нэгдүгээр, албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар баталгаажуулсугай.
2. Аудитын тайланг санхүүгийн аудитын газар болон Өмнөговь аймгийн Засаг даргад тус тус хүргүүлэхийг ахлах аудитор (Г.Шижирболд)-т үүрэг болгосугай.
3. Аудиттай холбоотой ажлын нотлох баримтыг архивын нэгж болгон хүлээлгэн өгөхийг аудитор (О.Чойдорж)-т даалгасугай.



Ц.ӨСӨХБЯЯР

4626010025